

БАТЛАВ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА И.БАТТӨГС

2024 оны дугаар сарын ...

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН АРЧИЛГАА, ЦЭВЭРЛЭГЭЭГ
ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.05.10

Улаанбаатар хот

| | |
|--|---|
| Үйлчилгээний байгууллага сонгон шалгаруулах үндэслэл | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Чиг үүрэг шилжүүлэх тухай” А/1461 дүгээр захирамж |
| Захиалагч байгууллага | Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| Ерөнхий шаардлага | Баянзүрх дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цас, мөс, хог хаягдал цэвэрлэх, халтиргаа, гулгаанаас урьдчилан сэргийлж давс, бодис цацах, угаалга цэвэрлэгээ, арчилгааг зохион байгуулах |
| Хугацаа: | Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно |
| Үндсэн үйл ажиллагаа | <ol style="list-style-type: none">1. Хотын гол гудамж, зам талбай, туслах зам, хороолол доторх зам, талбайн цэвэрлэгээг хийхэд шаардлагатай тусгай зориулалтын техник хэрэгсэлтэй байх.2. Авто замын зорчих хэсгийн цэвэрлэгээг гүйцэтгэхдээ ослоос сэргийлсэн цацруулагч бүхий түмбийг цэвэрлэгээний талбайгаас 30 хүртэлх метрийн зайнд байрлуулах бусад хамгаалалтын хувцас, тэмдэг, тэмдэглэгээг ашиглана.3. Нийтийн эдэлбэр газар, авто зам, явган хүний зам, талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг авто замын ус зайлуулах ил, далд шугам сүлжээ, үзлэгийн худагт хаяхгүй байх, хог хаягдлыг ил задгай овоолж салхиар тархах, хийсэхээс сэргийлэн зориулалтын хогийн саванд хадгалж, тээвэрлэж ажиллана.4. Нийтийн эдэлбэр газар, зам, талбайд байрлуулсан хогийн савны хог хаягдлыг хогийн сав дүүрч, халихаас өмнө давтамж харгалзахгүй суллаж цэвэрлэх.5. Гадна температур +5 градусаас дээш байх тохиолдолд чийгтэй цэвэрлэгээ хийнэ.6. Өвлийн улиралд цас, мөсийг хайлуулах зориулалтаар цацсан давс, тусгай зориулалтын бодис бүхий цас, мөсийг ногоон байгууламжийн талбайд хаяхгүй байх, гудамж талбайд 24 цагаас дээш хугацаагаар орхихгүй байх нөхцөлийг бүрдүүлж, тухай бүр ачиж тээвэрлэнэ.7. Авто зам, явган хүний замын хайс, хашлага, нийтийн эдэлбэр газар, зам талбайн хогийн сав, сандал бусад архитектурын байгууламжийг сард хоёроос доошгүй удаа угааж цэвэрлэнэ.8. Өвлийн улиралд хариуцсан авто замын халтиргаа гулгааг цас орсон даруйд нягтаршиж, мөстөхөөс өмнө халтиргаа, гулгаа арилгах тусгай зориулалтын бодис, давсыг цацаж, замын хөдөлгөөний хэвийн үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэх.9. Хариуцсан гудамж зам дагуух гэрлийн шон, барилгын хана, хашаан дээр наасан зарыг тогтмол хуулж, цэвэрлэх, зарлал наахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах. |


| | <p>10. Хариуцсан гудамж, замын 2 талын хананаас хана, хашаанаас хашаа хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн зорчих хэсэг, тусгаарлах зурвас явган хүний зам, ногоон байгууламж, шороон болон хатуу хучилттай бусад талбайн хог хаягдлыг цэвэрлэж, халтиргаа гулгааг арилгана.</p> <p>11. Автобусны буудлын цэвэрлэгээ, үйлчилгээг тухай бүр хийх.</p> <p>12. Ажилд гарахын өмнө хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг тогтмол танилцуулан, ажлын хувцас, хэрэглэлийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тухайн өдрийн ажил гүйцэтгэх зааварчилгааг өгч, ажилтан бүрээр гарын үсэг зуруулж, тэмдэглэл хөтлөх.</p> <p>13. Хууль, журам, ажил үүргийн тодорхойлолт, хуваарь, цэвэрлэгээний арга зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, харилцаа, ёс зүйн хэм хэмжээг багтаасан чиглүүлэх сургалтад хамрагдсан зам талбайн үйлчлэгч, жолооч, ачигч, ажилтнуудыг ажиллуулах.</p> | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|--|--|--|---------------------|---|----------------------|---|--|----------------------|--|-------------------|---|-----------------------------|---|-----------------------|------------------|--------|----------------------|----|---|------------------|----|---|---|-------------------|------------------|
| Хүний нөөцийн чадамж | <p>Зам талбайн арчилгаа, цэвэрлэгээний үйлчилгээ үзүүлэх байгууллагад дараах шаардлагууд тавигдана.</p> <table border="1" data-bbox="566 763 1444 1218"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Мэргэжил</th> <th>Үндсэн ажилтан эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>ХАБЭА</td> <td>1</td> <td>Сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй байна</td> <td>Үндсэн ба гэрээт</td> </tr> <tr> <td>2</td> <td>Зам талбайн мастер, инженер</td> <td>1</td> <td>Дээд мэргэжилтэй байх</td> <td>Үндсэн ба гэрээт</td> </tr> <tr> <td>3</td> <td>Зам талбайн үйлчлэгч</td> <td>20</td> <td></td> <td>Үндсэн ба гэрээт</td> </tr> <tr> <td>4</td> <td>Хог тээврийн жолооч</td> <td>3</td> <td>С ангилалтай байх</td> <td>Үндсэн ба гэрээт</td> </tr> </tbody> </table> | № | Албан тушаал | Хүний тоо | Мэргэжил | Үндсэн ажилтан эсэх | 1 | ХАБЭА | 1 | Сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй байна | Үндсэн ба гэрээт | 2 | Зам талбайн мастер, инженер | 1 | Дээд мэргэжилтэй байх | Үндсэн ба гэрээт | 3 | Зам талбайн үйлчлэгч | 20 | | Үндсэн ба гэрээт | 4 | Хог тээврийн жолооч | 3 | С ангилалтай байх | Үндсэн ба гэрээт |
| № | Албан тушаал | Хүний тоо | Мэргэжил | Үндсэн ажилтан эсэх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ХАБЭА | 1 | Сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй байна | Үндсэн ба гэрээт | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Зам талбайн мастер, инженер | 1 | Дээд мэргэжилтэй байх | Үндсэн ба гэрээт | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Зам талбайн үйлчлэгч | 20 | | Үндсэн ба гэрээт | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Хог тээврийн жолооч | 3 | С ангилалтай байх | Үндсэн ба гэрээт | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Тавигдах шаардлага: | <p>Зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх, халтиргаа гулгааг арилгах, цэвэрлэх тусгай зориулалтын техник, багаж хэрэгсэлтэй байна. Үүнд:</p> <table border="1" data-bbox="566 1346 1459 2018"> <thead> <tr> <th>Маши́н механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт</th> <th>Хүчин чадал</th> <th>Тоо ширхэг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх автомашин</td> <td>2 тн ба түүнээс дээш</td> <td>2</td> </tr> <tr> <td>Давс, бодис цацах тусгай зориулалтын автомашин</td> <td>2 тн ба түүнээс дээш</td> <td>1</td> </tr> <tr> <td>Авто ачигч (ковш)</td> <td></td> <td>1</td> </tr> <tr> <td>Тусгай зориулалтын техник хэрэгсэл (шүүр, сорогч)</td> <td>8 тн ба түүнээс дээш</td> <td>1</td> </tr> <tr> <td>Бобкат</td> <td></td> <td>1</td> </tr> <tr> <td>Зам талбайн хог цэвэрлэх шүүр, тармуур, хогийн сав, тумба</td> <td></td> <td>40</td> </tr> <tr> <td>Зам талбайн дагтаршсан цас цэвэрлэх цохиур буюу цавчуур</td> <td></td> <td>40</td> </tr> </tbody> </table> <p>Автомашин, тусгай техник хэрэгсэл нь өөрийн эзэмшлийнх байна.</p> | Маши́н механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт | Хүчин чадал | Тоо ширхэг | Зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх автомашин | 2 тн ба түүнээс дээш | 2 | Давс, бодис цацах тусгай зориулалтын автомашин | 2 тн ба түүнээс дээш | 1 | Авто ачигч (ковш) | | 1 | Тусгай зориулалтын техник хэрэгсэл (шүүр, сорогч) | 8 тн ба түүнээс дээш | 1 | Бобкат | | 1 | Зам талбайн хог цэвэрлэх шүүр, тармуур, хогийн сав, тумба | | 40 | Зам талбайн дагтаршсан цас цэвэрлэх цохиур буюу цавчуур | | 40 | |
| Маши́н механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт | Хүчин чадал | Тоо ширхэг | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх автомашин | 2 тн ба түүнээс дээш | 2 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Давс, бодис цацах тусгай зориулалтын автомашин | 2 тн ба түүнээс дээш | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Авто ачигч (ковш) | | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Тусгай зориулалтын техник хэрэгсэл (шүүр, сорогч) | 8 тн ба түүнээс дээш | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Бобкат | | 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Зам талбайн хог цэвэрлэх шүүр, тармуур, хогийн сав, тумба | | 40 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Зам талбайн дагтаршсан цас цэвэрлэх цохиур буюу цавчуур | | 40 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Зам талбайн цэвэрлэгээний ажилд | <ul style="list-style-type: none"> Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2020 оны "Энгийн хог хаягдлыг, ангилах, цуглуулах тээвэрлэх, дахин | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |


| | |
|------------------------|---|
| мөрдөгдөж буй стандарт | <p>боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам” 32/03 дугаар тогтоол</p> <ul style="list-style-type: none"> Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамж UCS1704A Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент UCS1701A |
| Үр дүнг тайлагнах: | Сар бүр гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ, түүнтэй холбогдох баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж ажиллана. |

Цэвэрлэгээ, үйлчилгээг гүйцэтгэх зам талбайн нэршил, тоо хэмжээ

| № | Талбайн нэршил | Талбайн эхлэл төгсгөл | Замын урт, м | Замын өргөн, м | Нийт талбай, м.кв | Тариф | Сард цэвэрлэх давтамж |
|------|---|--|--------------|----------------|-------------------|-------|-----------------------|
| 1 | Улиастайн зам | Улиастайн гүүрнээс Гачууртын эцэс хүртэл | 11,500 | 10 | 115,000 | 70 | 9 |
| 2 | Арцатын амын зам | Гачууртын эцсээс Арцатын ам хүртэл | 4,700 | 10.1 | 47,470 | 70 | 5 |
| 3 | Баатархайрхан давсан зам | Улиастайн шинэ эцсийн буудлаас зүүш тийш Баатархайрхан даваад Гачууртын зам хүртэл | 2,322 | 9 | 20,898 | 70 | 7 |
| 4 | Хужирбулангийн зам | Гачууртын замаас 28 дугаар хороо хүртэл | 1,000 | 10 | 10,000 | 70 | 6 |
| 5 | 20 дугаар хорооны зам | Гачууртын замаас 20 дугаар хороо хүртэл | 113,3 | 10 | 1,133 | 70 | 7 |
| 6 | 85 дугаар сургууль, эмнэлэг хүртэлх зам | Гачууртын замаас 85 дугаар сургууль, эмнэлэг хүртэлх зам | 700 | 7.85 | 5,500 | 70 | 5 |
| Нийт | | | | | 200,000 | | |



ХЯНАСАН:
 ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН
 ДАРГА  Н.БИЛЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:
 АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ
 ТАСГИЙН ДАРГА  М.БАТ-ЭРДЭНЭ